АШУҮИС болон Этүгэн их сургууль сувилагч мэргэжлийн үнэ цэнийн талаарх оюутнуудын ойлголтыг судалсан дүн

Сарангоо (Sarengaowa Lang)[1,2], Г.Хулан[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн энхим
[2]Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Хянган Аймгийн Ардын эмнэлэгийн хороо
Цахим шуудан: gnu23e010@gt.mnums.edu.mn, Утас: 88688559

Түлхүүр үг:
Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ
Сувилахуй оюутан
Монгол улс

Товч утга:
Үндэслэл: Сувилахуйн мэргэжлийн үнэ цэнэ нь мэргэжлийн үйл ажиллагаа, стандарт, үнэлгээ болон хүний нэр төр, шударга байдал, өгөөмөр сэтгэл, шударга ёсны мэргэжлийн сувилахуйн зарчмууд гэж тодорхойлогддог. Үнэт зүйлс гэдэг нь мэргэжилд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд сувилагч мэргэжлийн хувьд хүнлэг энэрэнгүй, хариуцлагатай байхыг шаарддаг. Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэт зүйлс нь сургалтын хөтөлбөрөөс ихээхэн өөрчлөгддөг байж болох бөгөөд энэ нь мэргэжлийн үнэт зүйлсийг сувилахуйн оюутнуудын сургалтын хөтөлбөрт интеграцчилж оруулах шаардлагатай төдийгүй сувилахуйн оюутнуудын дунд мэргэжлийн үнэт зүйлсийг судлахад харицаа байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэ цэний талаарх ойлголтыг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн судалгааны загвараар хийсэн. Улаанбаатар хотын хоёр их, сургуулийн сувилахуйн оюутнуудаас давхрагатайтүүврийн аргаар нийт 353 оюутныг судалгаанд хамруулсан. Судалгаанд сувилахуйн мэргэжлийн үнэ цэнийг үнэлэх шинэчилсэн (NPVS-R) асуумжыг ашигласан. Судалгааны үр дүнгийн Статистик боловсруулалтыг SPSS-29.0 программыг ашиглаглан хийсэн. **Үр дүн:** Нийт 353 асуумж авснаас, хүчин төгөлдөр 345 асуумж ирсэнээс 240 нь АШУҮИС-иас, 105 нь Этүгэн их сургуулиас байсан бөгөөд цуглуулгын үр дүн 97.7% байв. Сувилахуйн оюутнуудын асуумжийн үр дүнгээс харахад сувилагч мэргэжлийн үнэ цэнийн ойлголтын түвшин өндөр байна. **Дүгнэлт:** Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн судалгаа олон улсын стандартад нийцсэн чухал үр дүнгүүдийг харуулж байна. АШУҮИС болон Этүгэн их сургуулийн оюутнуудын мэргэжлийн үнэлэмж өндөр байгаагаас сургалтын чанар, хөтөлбөрийн үр дүнтэй холбоотой юм. Бакалаврын оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн оноо илүү өндөр байна.

Үндэслэл: Сувилахуйн ажил мэргэжлийн үнэ цэнийг мэргэжлийн үйл ажиллагаа, стандарт, үнэлгээ, хүний нэр төр, шударга байдал, өгөөмөр сэтгэл, шударга ёс гэсэн зарчмаар тодорхойлдог байна.[1] Эдгээр үнэт зүйлс нь ажил мэргэжилдээ голлох үүрэг гүйцэтгэж, сувилагчдыг хүнлэг, энэрэнгүй, хариуцлагатай байхыг шаарддаг.

Дэлхийн сувилахуй, эх барихуйн стратегийн 2021–2025 оны тэргүүлэх чиглэлийн нэг нь чанартай боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг хангах чадвартай эх баригч, сувилагч бэлтгэх юм. ДЭМБ-ын судалгаагаар 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн зорилт (SDG)-3 эрүүл мэнд, сайн сайхан байдалд хүрэхийн тулд дэлхий нийтэд 9 сая сувилагч, эх баригч шаардлагатай байна гэж тооцоолсон байна. Дэлхий дахинд болон Монгол улсад сувилагч, эх баригч мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна. Сувилагч нарын ажил мэргэжилд ажлын ачаалал их, цалин хөлс бага, ажиллах орчин таагүй, мэргэжлийн байр суурь, үнэлэмж доогуур байх зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байгааг судлаачил судаласан байна. Сувилач мэргэжлийн үнэ цэний талаар ойлголт нь

дутмаг байх нь, эрүүл мэндийн салбарын сувилагч мэргэжлийн үнэ цэнийг төлөвшүүлэх, олон нийтийн чанар сайтай сувилахуйн үйлчилгээний хэрэгцээг хангаах бэрхшээл үүсгэсээр байгааг судалгаанд тэмдэглэсэн байна. Анагаах ухаан, биоанагаах ухаан, байгалийн ухаан, технологи, сувилахуйн мэргэжил, онол тасралтгүй хөгжихийн хэрээр уламжлалт "Өвчин төвтэй" сувилахуйн загвар аажмаар "Хүн төвтэй" хүмүүнлэгийн сувилахуйн загвараар солигдож байгааг судлаачид онцлон тэмдэглэсэн байна.[2]

Зорилго: Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэ цэний талаарх ойлголтыг судалах.

Зорилт:

1. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн оюутнуудын мэргэжлийн үнэ цэнийн талаарх ойлголт, мэдлэгийг судлах
2. Этүгэн Их Сургуулийн сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэ цэнийн талаарх ойлголт, мэдлэгийг судлах
3. АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль болон Этүгэн Их Сургуулийн сувилахуйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын мэргэжлийн үнэ цэнийн талаарх ойлголтийн түвшинг хүн ам зүйн үзүүлэлтэй уялдуулан судлах.

Арга, аргачлал: Бид судалгааг агшингийн судалгааны загвараар хийсэн. Улаанбаатар хотын хоёр их, дээд сургуулийн сувилахуйн оюутнуудаас давхаргат түүвэрлэлтийн аргаар нийт 353 оюутныг судалгаанд хамруулсан. Сувилахуйн мэргэжлийн үнэ цэнийг үнэлэх шинэчилсэн асуумж (NPVS-R) нь нийт 5 бүлэг 26 асуултаа бүрдэнэ: 1) итгэлцэл, 2) шударга ёс, 3) мэргэжлийн ур чадвар, 4) идэвх, 5) халамж. Үнэлгээг Ликертийн 1-5 онооны хэмжүүрээр үнэлэв. Судалгааны ажлыг эхлүүлэн ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 05 сарын 17-нь өдрийн (Хурлын дугаар №2024/3-05) хэлэлцүүлэн судалгааг эхлүүлэх зөвшөөрөл авч хийж гүйцэтгэв.

Мэргэжлийн үнэ цэний үнэлгээг нийт 130 оноогоор дүгнэгдэх бөгөөд онооны хүрээ нь 26-130 хооронд байв. Хэрэв оноо 43-аас доош байвал мэргэжлийн үнэ цэнийн ач холбогдол "Бага" гэж ангилав; 43-86 хооронд байвал "Дунд", харин 86-аас дээш оноо авсан тохиолдолд "Өндөр" гэж үнэлэв.[3]

Судалгааны үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS-29.0 программыг ашиглан өгөгдлийг кодолж, шивж алдааг шалгасны дараа боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн. Дескриптив статистикийн шинжилгээгээр дундаж утга, стандарт хазайлт шинжилсэн, хөтөлбөрийн хоорондын ялгааг t- тест дүн шинжилгээ хийсэн. P утга<0.05 үед статистикийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд нийт 345 сувилахуйн оюутан хамрагдсанаас 333 нь эмэгтэй (96.54%), 12 нь эрэгтэй (3.46%) байв. Судалгаанд оролцогчдын дундаж нас 21.69±3.75 жил байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл (n=345)

Хүн ам зүйн үзүүлэлтүүд	Тоо (n)	Хувь (%)
Нас (насны хүрээ=(18~45), Mean=21.69, SD=3.75)		
15~24 нас	317	91.9
25~44 нас	26	7.5
45~65 нас	2	0.6
Гэрлэлтийн байдал		
Гэрлэсэн	30	8.70
Гэрлээгүй	315	91.30
Сургууль		
АШУҮИС, СС	240	69.60
Этүгэн Их Сургууль	105	30.40
Дамжаа		
Дипломын II	48	13.90
Дипломын III	45	13.00
Бакалаврын II	88	25.50
Бакалаврын III	63	18.30
Бакалаврын IV	101	29.30
Голч оноо		
A: 3.5-4	82	23.80
B: 3-3.5	175	50.70
C: 2-2.9	81	23.50
D: 1-1.9	7	2.00
Дадлагын хугацаа		
< 21хоног	176	51.00
≥ 30хоног	169	49.00

Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн дундаж оноо 104.93±15.гэж тодорхойлогдлоо. Хүчин зүйл бүрийн дундаж оноог тус бүрт нь авч үзэхэд болно гэж тодорхойлогдолоо."Халамж"-ийн үзүүлэлтийн дундаж шат 36.307±5.481-тай байв. Харин "Идэвх"-ийн дундаж оноо 19.362±3.388-тай, хамгийн бага нь "Шударга ёс" -ны үзүүлэлтийн дундаж нь 12.397±2.352 тус тус байлаа. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Сувилахуйн оюутнуудын дунд мэргэжлийн үнэлэмжийн таван хүчин зүйлсийн оноо

Үзүүлэлт	Тоо	Дундаж± стандарт хазайлт	Дундаж/ тоо	түвшин
Итгэлцэл	5	20.38±3.432	4.076	өндөр
Шударга ёс	3	12.397±2.352	4.132	өндөр
Мэргэжлийн ур чадвар	4	16.484±2.932	4.121	өндөр
Идэвх	5	19.362±3.388	3.872	өндөр
Халамж	9	36.307±5.481	4.034	өндөр
Нийт	26	104.93±15.205	4.036	өндөр

АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлгээний дундаж оноо 104.67 байгаа нь тэдний мэргэжлийн үнэлэмжийн түвшин өндөр байгааг харуулж байна. Мөн Этүгэн Их Сургуульд сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн дундаж оноо 105.52 байгаа нь энэ сургуулийн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн түвшин өндөр байгааг харуулж байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. АШУҮИС болон Этүгэн Их сургуулийн сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн түвшнийг үнэлсэн дүн

Сургууль	Тоо	Дундаж± стандарт хазайлт	Түвшин
АШУҮИС-ийн Сувилахуйн Сургууль сургууль	240	104.671±14.791	өндөр
Этүгэн Их Сургууль	105	105.524±16.169	өндөр

Хэлцэмж: Сувилахуйн мэргэжлийн үнэ цэн нь хувь хүний үнэ цэний тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд сувилахуйн ажилтнуудын өнөөгийн болон ирээдүйд сувилахуйн ажилд итгэх итгэл, хандлагыг харуулж байна. Энэ нь асран хамгаалагчдын карьер дахь үнэ цэний хандлага юм.[8] Зөв, эерэг мэргэжлийн үнэ цэн нь хувь хүний ажил мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулах төдийгүй, мөн сувилахуйн ерөнхий ахиц дэвшил, тогтвортой байдлыг дэмждэг гэжээ.[4] Энэхүү судалгаагаар хоёр их сургуулийн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн оноо өндөр түвшинд хүрсэн нь хэний үр дүнтэй дүйж байна мөн оюутануудад мэргэжлийн үнэ цэн нь эерэг үзүүлэлтэй байгааг харуулж байна.[5-8] АШУҮИС-ийн сувилахуйн сургууль нь үндэсний бодлогод тулгуурласан сувилахуйн боловсролын загварыг төлөөлдөг бол Этүгэн Их Сургууль нь хувийн боловсролын төлөөлөл болох зах зээлийн эрэлт хэрэгцээ, сургалтын уян хатан байдалд түлхүү анхаардаг.

Энэхүү судалгаагаар АШУҮИС-ийн сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн оноо 104.671±14.791, Этүгэн Их сургуулийнх 105.524±16.169 байсан нь эдгээр хоёр төрлийн оюутнуудын мэргэжлийн үнэлэмж илүү хүчтэй байгааг харуулж байна. Туркийн 2021 оны Шейма Инцисер Пашалак нарын судалгааны үр дүнтэй уялдуулан Туркийн сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн оноо 105.8±16.5 байсан нь энэ судалгаанд хамрагдсан хувийн их сургуулиудын оноотой ойролцоо байна.[9] Үүнээс үзэхэд Турк, Монголын сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмж, ялангуяа дээд боловсролтой сургуулиудад ижил төстэй байдал байгаа нь сувилахуйн боловсролын тогтолцоонд ёс зүй, эмнэлзүйн практикийг онцолсонтой холбоотой байж болох юм. Хоёр улсын сувилахуйн боловсролын тогтолцоо ижил төстэй ч Монгол, Туркийн сувилахуйн мэргэжлийн соёл, нийгмийн ойлголт, статусын хувьд ялгаатай байдаг. Энэхүү судалгаа нь Монгол улсын үндэсний болон хувийн их сургуулиудын сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийг харьцуулсан анхны судалгаа бөгөөд хувийн их сургуулийн оюутнууд мэргэжлийн үнэлэмж арай илүү өндөр байдаг нь сургуулийн төрөл, боловсролын нөөц нь мэргэжлийн үнэлэмжид хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна. Түүнчлэн энэхүү судалгаа нь Монголын сувилахуйн оюутнуудын голч оноо болон мэргэжлийн үнэлэмжийн хоорондын уялдаа холбоог судалсан анхны судалгаа бөгөөд сурлагын амжилт сайтай оюутнуудын мэргэжлийн үнэлэмж илүү хүчтэй байдаг бол Турк судлал энэ тал дээр хангалттай анхаарал хандуулаагүй байна. Энэхүү судалгаа нь сурлагын амжилт, мэргэжлийн ёс зүй хоёрын хооронд эерэг хамаарал байгааг харуулж байгаа нь сувилахуйн боловсролын чанарыг сайжруулах шинэ үндэслэл болж байна.

Судлаач Портиа Бимрай нарын 2023 онд Өмнөд Африкт хийсэн судалгаагаар сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн оноо 110.5±12.3 байсан нь энэ судалгаанд Монголын хоёр их сургуулийн сувилахуйн оюутнуудын онооноос хамаагүй өндөр байна (АШУҮИС-ийн сувилахуйн сургууль нь 104.671±14.791 ба Этүгэн Их сургууль нь 105.524±16.169 байсан бөгөөд энэ нь өөр өөр улс орон, соёлын гарал үүсэл дэх мэргэжлийн үнэт зүйлсийн ялгааг харуулсан.[10]

Өмнөд Африкийн судалгаагаар сургуулийн төрөл (үндэсний болон хувийн) мэргэжлийн үнэлэмжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй бол энэ судалгаагаар Монголын хувийн их сургуулиудын сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмж нь үндэсний их сургуулийн оюутнуудынхаас арай өндөр байгааг тогтоожээ. Их сургуулиуд, сургуулийн төрөл, боловсролын нөөц нь мэргэжлийн үнэлэмжид тодорхой нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна. Болзошгүй шалтгаан нь Өмнөд Африкийн улсын болон хувийн их дээд сургуулиудын нөөц боломж харьцангуй тэнцвэртэй байдаг бол Монголын хувийн их сургуулиуд зах зээлийн эрэлт хэрэгцээ, практик ур чадварт илүү анхаардаг байж болох юм.

Дүгнэлт:

1. Сувилахуйн оюутнуудын мэргэжлийн үнэлэмжийн судалгаа нь олон улсын стандартад нийцсэн, чухал ач холбогдолтой үр дүнгүүдийг харуулж байна.
2. Улаанбаатар хотын АШУҮИС болон Этүгэн Их Сургуулийн сувилахуйн оюутнууд нь мэргэжлийн үнэлэмж өндөр оноотой байгаагаас үзвэл, тэдний сургалтын чанар, хөтөлбөрийн системийн үр дүнтэй холбоотой юм.
3. Сургалтын хөтөлбөр, оюутнуудын өөрийгөө танин мэдэх, мэргэжлийн төлөвлөлт зэргээр ялгаатай болохоор мэргэжлийн үнэлэмжийн оноо бакалаврын сувилахуйн оюутнуудын дунд илүү өндөр байна.

Ном зүй:

1. *Schmidt Bj, Mcarthur Ec. Professional Nursing Values: A concept analysis. Wiley Online Library; 2018:69-75.*
2. *Mcallister M, Lasater K, Stone Te, Levett-Jones T. The reading room: Exploring the use of literature as a strategy for integrating threshold concepts into nursing curricula. Nurse education in practice. 2015;15(6):549-555.*

3. Weis D, Schank Mj. Development and psychometric evaluation of the Nurses Professional Values Scale. Journal of nursing measurement. 2009;17(3)
4. 史文文. 护理专业学生与护士专业价值观的调查研究. 北京: 北京中医药大学; 2010.
5. Fisher M. A comparison of professional value development among pre-licensure nursing students in associate degree, diploma, and bachelor of science in nursing programs. Nursing education perspectives. 2014;35(1):37-42.
6. Moon S, Kim Dh, Kim Ej, Kim Y-J, Lee S. Evaluation of the validity and reliability of the Korean version of the Nursing Professional Values Scale—Revised. Nurse education today. 2014;34(3):325-330.
7. Poorchangizi B, Borhani F, Abbaszadeh A, Mirzaee M, Farokhzadian J. The importance of professional values from nursing students' perspective. BMC nursing. 2019;18:1-7.
8. Nazari Am, Borhani F, Zare-Kaseb A, Yousofvand V, Abbaszadeh A. The relationship between moral reasoning and nurses' professional values in undergraduate nursing students: a descriptive-correlational study. BMC Medical Education. 2024;24(1):889.
9. Aktas Yy, Karabulut N. Professional values in Turkish undergraduate nursing students and its reflection on caring behaviour. Kontakt. 2017;19(2):e116-e121.
10. Bimray P, Chipps J, Ticha V. Professional values of undergraduate students at a nursing school in south africa. Nursing Research and Practice. 2023;2023(1):9635033.

The value of nursing profession among nursing student's perspectives

Sarengaowa Lang[1,2], Khulan G

[1]Department of Public Health Nursing, School of Nursing, MNUMS
[2]Xing'an League People's Hospital, China
E-mail: gnu23e010@gt.mnums.edu.mn, Tel:+976-88688559

Background: The professional values of nursing are defined by professional activities, standards, evaluations, as well as principles of human dignity, fairness, generosity, and justice in the nursing profession. Values play a key role in the profession and require nurses to be compassionate, responsible, and ethical. The professional values of nursing students may vary significantly depending on the curriculum, suggesting the need to integrate professional values into the nursing students' educational programs. This study aims to explore the importance of professional values among nursing students.
Aim: To examine nursing students' knowledge understanding of professional values.
Materials and Methods: The study was conducted using a cross-sectional research design. A total of 353 nursing students from two universities in Ulaanbaatar city were surveyed using a stratified sampling method. The updated Nursing Professional Value Scale (NPVS-R) questionnaire was used to assess the professional values of nursing students. Statistical analysis of the data was performed using SPSS version 29.0.
Results: A total of 353 questionnaires were collected, of which 345 were valid, with 240 from the Mongolian National University of Medical Sciences (MNUMS) and 105 from Etugen University, resulting in a response rate of 97.7%. According to the results of the nursing students' questionnaires, the level of understanding of the value of the nursing profession is high.
Conclusions:

1. The study on the professional evaluation of vocational students shows significant results that are in line with international standards.
2. The Nursing Faculties of the Mongolian National University of Medical Sciences and Etugen University in Ulaanbaatar received high professional evaluation scores, indicating the quality of their education and the effectiveness of their curriculum systems.
3. Since the curriculum, students' self-awareness, and professional planning differ, the professional evaluation scores are higher among bachelor's degree nursing students.

Keywords: Nursing professional values, Nursing students, Mongolia